



УЛААНБААТАР
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2021 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 6/350

Улаанбаатар хот

Л.Оюуныг ажлаас чөлөөлөх,
тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, компанийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.23, компанийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2019-2020 онд мөрдөх Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.14 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хангамж үйлчилгээний албаны мэргэжилтэн Лувсандамдингийн Оюун /121567/ нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан тул 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалсугай.

2. Л.Оюуны эрчим хүчний салбарт 21 жил ажилласны тэтгэмжийг эрчим хүчний салбарт ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /672000/-г 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцож 28 224 000 /хорин найман сая хоёр зуун хорин дөрвөн мянга/ төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгосугай.

3. Нэг удаагийн тэтгэмжийг 28 224 000 /хорин найман сая хоёр зуун хорин дөрвөн мянга/ төгрөгөөр тооцож олгохыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /О.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.

4. Л.Оюуны ажлыг 2 өдөрт багтаан хүлээлцүүлж холбогдох тооцоог хийж дуусгахыг Хангамж үйлчилгээний албаны дарга /Ш.Оюунчимэг/-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /Б.Баттүшиг/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.ДАГДАН

e:\2021 он\ashiglalt-2\зхнх\тэтгэвэрт гаргах.docx

3170602313